

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/100/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn  Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn  Аудитор: Э.Эрдэнэбат Утас: 99352099 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт .....	18
5.2 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОУС	Олон улсын съандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН 4 ДҮГЭЭР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Д.ДЭЛГЭРБАЯР ТАНАА

2025.02.25 № 94

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант хугацаанд Боловсролын ерөнхий газраас шилжүүлсэн 68,815.3 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 2,314,146.3 сянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 37.9 хувиар өссөн байна.

## **Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 14 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 93.5 хувиар гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР




## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>392,285,207.18</b>	<b>239,411,926.16</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>292,801,290.62</b>	<b>205,103,605.50</b>
312	Банканд байгаа бэлэн мөнгө		-
3121	төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах	292,801,290.62	205,103,605.50
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага		
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>99,483,916.56</b>	<b>34,308,320.66</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>2,592,883.00</b>	<b>2,372,883.00</b>
3511	Тусгай зориулалттай материал	-	-
3513	Эм боох материал	2,592,883.00	2,372,883.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>96,891,033.56</b>	<b>31,935,437.66</b>
35410	Бичиг хэргийн материал	8,825,819.80	40,700.00
35420	Аж ахуйн материал	53,833,781.76	12,143,495.66
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	-	-
3545	Барилгын засварын материал	10,639,400.00	211,700.00
3546	Хүнсний материал	5,226,550.00	1,255,460.00
35470	Бусад хангамжийн материал	18,365,482.00	18,284,082.00
36	НӨӨЦ БАРАА		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,152,138,081.74</b>	<b>8,153,781,887.63</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>8,152,138,081.74</b>	<b>8,153,781,887.63</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>7,652,294,081.50</b>	<b>7,654,287,887.57</b>
39201	Барилга, байгууламж орон сууц	6,848,330,151.00	6,848,330,151.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(249,666,865.22)	(307,361,026.22)
39203	Авто тээврийн хэрэгсэл	-	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	893,911,017.65	1,001,140,862.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	(499,583,719.71)	(546,152,674.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	444,988,512.08	469,858,512.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	(106,206,402.24)	(124,612,002.52)
39214	Бусад үндсэн хөрөнгө	308,223,927.02	308,223,927.02
39215	Хуримтлагдсан элэгдэл	(41,497,602.32)	(48,934,925.30)
39217	Ном	53,795,063.24	53,795,063.24
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>499,844,000.24</b>	<b>499,494,000.06</b>
39301	Программ хангамж	9,120,550.00	9,120,550.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,820,549.76)	(3,170,549.94)

39303	Бусад биет бус хөрөнгө	493,544,000.00	493,544,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>8,544,423,288.92</b>	<b>8,393,193,813.79</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,544,423,288.92</b>	<b>8,393,193,813.79</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,544,423,288.92	8,393,193,813.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,176,264,984.77	2,176,264,984.77
51101	Өмч: - төрийн	2,176,264,984.77	2,176,264,984.77
512	Хуримтлагдсан үр дүн	5,060,866,517.20	4,909,637,042.07
51210	Өмнөх үеийн үр дүн	5,060,866,517.20	5,060,866,517.20
51220	Тайлант үеийн үр дүн	-	(151,229,475.13)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,307,291,786.95	1,307,291,786.95
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>8,544,423,288.92</b>	<b>8,393,193,813.79</b>




## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>8,285,936,039.39</b>	<b>3,041,746,245.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,716,607,875.39</b>	<b>89,105,645.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,716,607,875.39	89,105,645.00
<b>120004</b>	Төсөвт байгууллагын өөрийн орлого	23,867,648.00	20,290,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,438,200.00	5,029,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,429,448.00	15,260,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	5,673,014,893.64	68,815,345.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	19,725,333.75	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,569,328,164.00</b>	<b>2,952,640,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,390,563,700.00</b>	<b>2,834,666,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,390,563,700.00	2,834,666,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>178,764,464.00</b>	<b>117,974,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	178,764,464.00	117,974,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,460,190,580.42</b>	<b>3,192,975,720.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,460,190,580.42</b>	<b>3,192,975,720.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,460,190,381.34</b>	<b>3,192,484,842.36</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,677,714,922.09</b>	<b>2,314,146,288.98</b>
210101	Үндсэн цалин	1,205,437,130.59	1,495,460,160.15
210102	Нэмэгдэл	418,323,076.95	725,780,930.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	53,954,714.55	92,905,197.90
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>210,329,356.87</b>	<b>290,930,440.14</b>
210201	Тэтгэврийн даатгал	140,590,120.45	198,328,419.81
210202	Тэтгэмжийн даатгал	17,662,009.98	23,332,655.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,076,864.94	11,784,482.45
210204	Ажилгүйдлийн даатгал	3,454,637.72	11,496,816.53
210205	Эрүүл мэндийн даатгал	34,545,723.78	45,988,066.09
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>158,779,404.92</b>	<b>79,497,472.23</b>
210301	Гэрэл, цахилгаан	24,717,168.00	27,548,779.03
210302	Түлш, халаалт	114,475,643.00	32,850,616.48
210303	Цэвэр, бохир ус	19,586,593.92	19,098,076.72
210304	байрны түрээс	-	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,196,197.00</b>	-
210401	Бичиг хэрэг	250,900.00	-



210402	Тээвэр, шатахуун	1,945,297.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-
210408	Бараа материал акталсны зардал	-	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>132,515,881.00</b>	<b>149,611,230.00</b>
210502	Хоол, хүнс	132,515,881.00	149,611,230.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,319,800.00</b>	<b>21,754,650.00</b>
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,578,240.00	-
210604	Урсгал засвар	12,741,560.00	21,754,650.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-
210702	Дотоод албан томилолт	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>36,504,300.42</b>	<b>44,165,726.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,985,300.00	5,029,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	-
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,519,000.42	39,136,226.00
210807	Газрын төлбөр	-	-
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>227,830,519.04</b>	<b>292,379,035.01</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,763,346.75	140,201,025.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,542,050.00	21,721,970.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	179,525,122.29	130,456,039.11
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>199.08</b>	<b>490,877.77</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>199.08</b>	<b>490,877.77</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	199.08	490,877.77
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>5,825,745,458.97</b>	<b>(151,229,475.13)</b>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,222,147.00	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	15,222,147.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(15,222,147.00)	
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>5,810,523,311.97</b>	<b>(151,229,475.13)</b>



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,593,195,812.00</b>	<b>2,972,930,900.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>23,867,648.00</b>	<b>20,290,300.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>23,867,648.00</b>	<b>20,290,300.00</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,438,200.00	5,029,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,429,448.00	15,260,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,569,328,164.00</b>	<b>2,952,640,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,390,563,700.00</b>	<b>2,834,666,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,390,563,700.00	2,834,666,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>178,764,464.00</b>	<b>117,974,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	178,764,464.00	117,974,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,295,438,099.38</b>	<b>2,997,344,085.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,295,438,099.38</b>	<b>2,997,344,085.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,159,452,241.30</b>	<b>2,851,213,067.35</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>1,665,164,866.96</b>	<b>2,313,896,288.98</b>
210101	Үндсэн цалин	1,192,887,075.46	1,495,210,160.15
210102	Нэмэгдэл	418,323,076.95	725,780,930.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	53,954,714.55	92,905,197.90
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>222,867,412.00</b>	<b>290,930,440.14</b>
210201	Тэтгэврийн даатгалын	153,128,202.58	198,328,419.81
210202	Тэтгэмжийн даатгалын	17,662,009.98	23,332,655.26
210203	ҮОМШӨ-ий даатгалын	14,076,864.94	11,784,482.45
210204	Ажилгүйдлийн даатгалын	3,454,637.72	11,496,816.53
210205	Эрүүл мэндийн даатгалын	34,545,696.78	45,988,066.09
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>158,779,404.92</b>	<b>79,497,472.23</b>
210301	Гэрэл, цахилгаан	24,717,168.00	27,548,779.03
210302	Түлш, халаалт	114,475,643.00	32,850,616.48
210303	Цэвэр, бохир ус	19,586,593.92	19,098,076.72
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материал</b>	-	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Нормын хувцас, зөөлөн эдлэл		



<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>21,563,100.00</b>	<b>37,985,650.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	1,578,240.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	19,984,860.00	37,985,650.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-
210702	Дотоодын томилолт	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,669,300.42</b>	<b>45,815,726.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,518,800.00	5,029,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	0.00
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	0.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,150,500.42	40,786,226.00
210807	Газрын төлбөр	0.00	-
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>53,408,157.00</b>	<b>83,087,490.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,718,507.00	57,265,590.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	20,689,650.00	25,821,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>135,985,858.08</b>	<b>146,131,017.77</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>135,985,659.00</b>	<b>145,640,140.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	135,985,659.00	145,640,140.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>199.08</b>	<b>490,877.77</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	199.08	490,877.77
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>297,757,712.62</b>	<b>(24,413,185.12)</b>
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн	-	-
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	69,402,600.00	63,284,500.00
0	Дотоод эх үүсвэр	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	69,402,600.00	63,284,500.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(69,402,600.00)	(63,284,500.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	228,355,112.62	(87,697,685.12)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	292,801,290.62
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	205,103,605.50



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
S01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,176,264,984.77	1,307,291,786.95	5,188,159,831.43	-	8,671,716,603.15
S02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
S03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,176,264,984.77	1,307,291,786.95	5,188,159,831.43	-	8,671,716,603.15
S04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
S05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
S06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
S07	Тайлант үеийн үр дүн			(127,293,314.23)		(127,293,314.23)
S08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,176,264,984.77	1,307,291,786.95	5,060,866,517.20	-	8,544,423,288.92
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,176,264,984.77	1,307,291,786.95	5,060,866,517.20	-	8,544,423,288.92
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			(151,229,475.13)		(151,229,475.13)
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,176,264,984.77	1,307,291,786.95	4,909,637,042.07	-	8,393,193,813.79

XTCF53663022399

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>3,265,732,200.00</b>	<b>3,060,137,707.35</b>	<b>(205,594,492.65)</b>	<b>93.7%</b>
21	Урсгал зардлын дүн	3,265,732,200.00	2,996,853,207.35	(268,878,992.65)	91.8%
<b>210</b>	<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>3,098,002,100.00</b>	<b>2,851,213,067.35</b>	<b>(246,789,032.65)</b>	<b>92.0%</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,425,577,100.00</b>	<b>2,313,896,288.98</b>	<b>(111,680,811.02)</b>	<b>95.4%</b>
210101	Үндсэн цалин	1,648,137,000.00	1,495,210,160.15	(152,926,839.85)	90.7%
210102	Нэмэгдэл	733,910,400.00	725,780,930.93	(8,129,469.07)	98.9%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	-	0.0%
210104	Урамшуулал	43,529,700.00	92,905,197.90	49,375,497.90	213.4%
210105	Гэрээт ажлын хөлс	-	-	-	0.0%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>303,197,200.00</b>	<b>290,930,440.14</b>	<b>(12,266,759.86)</b>	<b>96.0%</b>
210201	Тэтгэврийн даатгал	206,174,100.00	198,328,419.81	(7,845,680.19)	96.2%
210202	Тэтгэмжийн даатгал	24,255,800.00	23,332,655.26	(923,144.74)	96.2%
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,127,900.00	11,784,482.45	(343,417.55)	97.2%
210204	Ажилгүйдлийн даатгал	12,127,900.00	11,496,816.53	(631,083.47)	94.8%
210205	ЭМД-ын хураамж	48,511,500.00	45,988,066.09	(2,523,433.91)	94.8%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>80,823,900.00</b>	<b>79,497,472.23</b>	<b>(1,326,427.77)</b>	<b>98.4%</b>
210301	Гэрэл, цахилгаан	28,399,079.03	27,548,779.03	(850,300.00)	97.0%
210302	Түлш, халаалт	32,850,616.48	32,850,616.48	-	100.0%
210303	Цэвэр, бохир ус	19,574,204.49	19,098,076.72	(476,127.77)	97.6%
210304	байрны түрээс	-	-	-	0.0%
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>38,000,000.00</b>	<b>37,985,650.00</b>	<b>(14,350.00)</b>	<b>100.0%</b>
210601	Багаж хэрэгсэл	-	-	-	0.0%
210602	Тавилга	-	-	-	0.0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	-	-	0.0%
210604	Урсгал засвар	38,000,000.00	37,985,650.00	(14,350.00)	100.0%
2107	Томилолт, зочны зардал	-	-	-	0.0%
210702	Дотоод томилолт	-	-	-	0.0%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>67,946,100.00</b>	<b>45,815,726.00</b>	<b>(22,130,374.00)</b>	<b>67.4%</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,029,500.00	5,029,500.00	-	100.0%
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	62,916,600.00	40,786,226.00	(22,130,374.00)	64.8%
210807	Газрын төлбөр	-	-	-	0.0%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>182,457,800.00</b>	<b>83,087,490.00</b>	<b>(99,370,310.00)</b>	<b>45.5%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	156,543,500.00	57,265,590.00	(99,277,910.00)	36.6%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,914,300.00	25,821,900.00	(92,400.00)	99.6%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>167,730,100.00</b>	<b>145,640,140.00</b>	<b>(22,089,960.00)</b>	<b>86.8%</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>

213101	Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг			-	0.0%
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>167,730,100.00</b>	<b>145,640,140.00</b>	<b>(22,089,960.00)</b>	<b>86.8%</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	167,730,100.00	145,640,140.00	(22,089,960.00)	86.8%
213208	хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			-	0.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	-	-	0.0%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-		0.0%
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг				0.0%
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	-		<b>0.0%</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг				0.0%
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-		0.0%
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг				0.0%
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>63,284,500.00</b>		<b>0.0%</b>
	Дотоод эх үүсвэрээр	-	63,284,500.00		0.0%
	Тоног төхөөрөмж				0.0%
	Бусад хөрөнгө				0.0%
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,265,732,200.00</b>	<b>2,972,440,022.23</b>	<b>(293,292,177.77)</b>	<b>91.0%</b>
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,127,467,900.00	2,834,666,600.00	(292,801,300.00)	90.6%
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,834,666,600.00	2,834,666,600.00	-	100.0%
	Өмнөх оны үлдэгдлээс	292,801,300.00		(292,801,300.00)	0.0%
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	<b>117,974,000.00</b>	<b>117,483,122.23</b>	<b>(490,877.77)</b>	<b>99.6%</b>
132001	Орон нутгийн төсвөөс	117,974,000.00	117,483,122.23	(490,877.77)	99.6%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	<b>20,290,300.00</b>	<b>20,290,300.00</b>	-	<b>100.0%</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,029,500.00	5,029,500.00	-	100.0%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,260,800.00	15,260,800.00	-	100.0%
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	<b>-</b>		<b>0.0%</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-		0.0%
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		292,801,290.62		0.0%
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		205,103,605.50		0.0%
<b>1</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				<b>0.0%</b>
<b>2</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	-	<b>100.0%</b>
<b>3</b>	<b>Төсвийн байгууллага</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	-	<b>100.0%</b>
	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>104.00</b>	<b>104.00</b>	-	<b>100.0%</b>
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
	Гүйцэтгэх ажилтан	76.00	76.00	-	100.0%
	Үйлчлэх ажилтан	27.00	27.00	-	100.0%



### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Тус сургууль нь Дархан сумын хамран сургах тойрог 1,2,3 дүгээр багийн 6-18 насны 1231 ерөнхий боловсролын олон талт үйл ажиллагааны явцад бие бялдар, танин мэдэхүй мэдлэг боловсролыг олгох, нийгэмшлийн хөгжлийг дэмжин хөгжүүлж, хүмүүжүүлэх, төлөвшүүлэх ажлыг бодлогын түвшинд чанарыг эрхэмлэн зохион байгуулан хэрэгжүүлж, их дээд сургуульд амжилттай бэлтгэн оруулах, эцэг эхийн гурвалсан холбоог бэхжүүлэх, хүүхдийн сурч хүмүүжих эрхийг ханган ажиллаж байна.

#### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр сургуулийн Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөр, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 04 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дархан Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 151,229.5 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	292,801.3	205,103.6	(87,697.7)
Авлага	-	-	-
Бараа материал	99,483.9	34,308.3	(65,175.6)
Үндсэн хөрөнгө	8,152,138.1	8,153,781.9	1,643.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,544,423.3</b>	<b>8,393,193.8</b>	<b>(151,229.5)</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,544,423.3	8,393,193.8	(151,229.5)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>8,544,423.3</b>	<b>8,393,193.8</b>	<b>(151,229.5)</b>

Тайлант онд төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэл 205,103.6 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 99,483.9 мянган төгрөг болж 65,175.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 239,686.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 304,276.4 мянган төгрөгийн материалыг зарцуулсныг тайланд бүрэн тусгажээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,153,781.9 мянган төгрөг болж 1,643.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгөөр 63,284.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Боловсролын ерөнхий газраас шилжүүлсэн 68,815.3 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлант хугацаанд 130,456.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,393,193.8 мянган төгрөг болж 151,229.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,211,028.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 117,974.0 мянган төгрөг, өөрийн орлогоос, 20,290.3 мянган төгрөг нийт 2,349,292.4 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж баталсан байна.

2024 оны батлагдсан төсвийг улсын төсвөөс 2,834,666.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 117,974.0 мянган төгрөг буюу нийт 2,952,640.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,834,666.6 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 292,801.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 117,974.0 мянган төгрөг, өөрийн орлогоос, 20,290.3 мянган төгрөг нийт 3,265,732.2 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 117,974.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 117,483.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 490.9 мянган төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвөөс 2,834,666.6 мянган төгрөгийн санхүүжилт, өөрийн орлого 20,290.3 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 87,697.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 2,942,654.6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 205,103.6 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,060,137.7 мянган төгрөг буюу 93.7 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 205,594.5 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>71802-Сургуулийн ерөнхий боловсрол олгох</b>				
1.1	80111- Тогтмол зардал	117,974.0	117,974.0	-	100.0%
1.2	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	6,344.3	4,337.2	(2,007.1)	68.4%
1.3	80233- Хүүхэд хамгаалал	6,656.2	6,064.4	(591.8)	91.1%
1.4	80312-Сургалт семинар	6,868.9	6,600.0	(268.9)	96.1%
1.5	81605-Эрүүл мэндийг зардал	6,478.1	6,463.7	(14.4)	99.8%
1.6	81807-Хоол хүнс	167,730.1	145,640.1	(22,090.0)	86.8%
1.7	81816-Хүүхдэд ээлтэй орчин	56,717.9	56,709.5	(8.4)	100.0%
1.8	81823- Багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	20,318.6	10,260.0	(10,058.6)	50.5%
1.9	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2,793,340.3	2,641,601.1	(151,739.2)	94.6%
1.10	81835-Боловсролын хэвийн үйл ажиллагааг хангах	46,200.6	46,200.6	-	100.0%
1.11	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	7,255.4	6,143.2	(1,112.2)	84.7%
1.12	81848-Сурах бичгийн түрээс	5,029.5	5,029.5	-	100.0%
1.13	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	14,436.6	7,114.3	(7,322.3)	49.3%
1.14	83603-Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан	10,381.7	-	(10,381.7)	0.0%
	<b>Дүн</b>	<b>3,265,732.2</b>	<b>3,060,137.7</b>	<b>(205,594.5)</b>	<b>93.7%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д "Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах

бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 76 ажилтан, үйлчлэх 27 ажилтан буюу нийт 104 ажилтантайгаар ажиллаж, 210801- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжын зардалд 5,029.5 мянган төгрөг, 210901- Бараа үйлчилгээний бусад зардалд 25,821.9 мянган төгрөгийг зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой 151,056.9 мянган төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалтыг төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч оролцогч ирээгүй байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд 151,056.9 мянган төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалтыг төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч оролцогч ирээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Шилэн дансны тухай хууль, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,460,190.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 24,601.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Дархан Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр сургуулийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 5 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээнээс 1 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Тус сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлээ.

### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны

орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах ...." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус сургуулийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар өгөгдөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр баталсан 2,211,028.1 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 623,638.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 88,768.2 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл буурч төсвийн гүйцэтгэл 93.8% хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

#### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 68,815.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тайланд онд Боловсрол, ерөнхий газрын шилжүүлсэн 68,815.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим" 5.1.4. "үнэн зөв байх" заалт, \_УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", Оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үндсэн хөрөнгийн тайланд бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 4,040.1 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэн тул зөрчлийг таслан зогсоох 952.1 мянган төгрөгийн акт, 3,088.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

---

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

## 5.1 Төлбөрийн акт

**5.1.1 Илрүүлэлт:** Тус сургуулийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 12-ний өдрийн А/13 тоот тушаалаар математикийн багш Б.Болормаад сахилгын шийтгэл ногдуулсан байхад 2024 оны 06 дугаар сард 840.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

**5.1.2 Илрүүлэлт:** Тус сургуулийн нярав С.Мэндбаярт 2024 оны 07 дугаар сард ажиллавал зохих 152 цагийн 10 хувь болох 15 цагийн илүү цагийн хөлс олгох байтал 28 цаг илүү ажилласнаар тооцон 112,101 төгрөгийг илүү олгосон нь Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3 дахь заалтад “Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

## 5.2 Албан шаардлага

Тайлант онд байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар “өөрчлөлтгүй” дүгнэлт авсан шалтгаанаар Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын А/141 дүгээр тушаалыг баримтлан сургуулийн захирлын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлж, 3,088.0 мянган төгрөгийн урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь хэсэгт заасантай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

## 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Тайлангийн 4.4.1, 4.4.2-т тусгагдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/										
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Зөвлөмж
Боловсрол, ерөнхий газрын шилжүүлсэн 68,815.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй байна.	1	68,815.3	1	68,815.3	-	-	1	68,815.3	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>68,815.3</b>	<b>1</b>	<b>68,815.3</b>	-	-	<b>1</b>	<b>68,815.3</b>	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус сургуулийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 12-ний өдрийн А/13 тоот тушаалаар математикийн багш Б.Болормаад сахилгын шийтгэл ногдуулсан байхад 2024 оны 06 дугаар сард 840.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.	1	840.0	1	840.0								
Тус сургуулийн нярав С.Мэндбаярт 2024 оны 07 дугаар сард ажиллалал зохих 152 цагийн 10 хувь болох 15 цагийн илүү цагийн хөлс олгох байтал 28 цаг илүү ажилласнаар тооцон 112,101 төгрөгийг илүү олгосон байна	1	112.1	1	112.1								

Тус сургуулийн захирал Д.Дэлгэр баярыг Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 2 дахин нэмэгдүүлэн 3,088.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	3,088.0					1	3,088.0										
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>4,040.1</b>	<b>2</b>	<b>952.1</b>	<b>1</b>	<b>3,088.0</b>	<b>1</b>	<b>3,088.0</b>	<b>-</b>									

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим системд, байгууллагын батлагдсан төсөв мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-	-	-	-	-	1	-
Тус сургуулийн Ахмадын тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>